


Намын Бага Чуулганы 2020 оны 03 дугаар сарын 22-ны  
өдрийн 04 дүгээр тогтоолоор батлав.

**АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМЫН**  
**2020 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



УРИА: БАЯЛАГ, БОЛОМЖ, БИЗНЕСИЙН ШУДАРГА ХУВААРИЛАЛТ.

Монголын ард түмэн-монгол хүн бүр бие эрүүл, сэтгэл саруул байж, хүсэл сонирхолдоо нийцсэн ажил хөдөлмөр эрхэлж, амьдралдаа хүрэлцэхүйц цалин-орлоготой, тохилог орон гэртэй, айх аюулгүй, амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх нь манай намын чин эрмэлзлэл-эрхэм зорилго мөн.

Манай нам 2020 оны УИХ-ын сонгуульд ард түмнээ дээдэлсэн хүмүүнлэг засаглал, нийгэм, эдийн засаг, байгаль экологи, аюулгүй орчны бодлогын хүрээнд “БАЯЛАГ, БОЛОМЖ, БИЗНЕСИЙН ШУДАРГА ХУВААРИЛАЛТ” уриа бүхий дараах хөтөлбөрийг Ард түмэн–Сонгогч олондоо дэвшүүлж байна.

**Нэг. Ард түмнээ дээдэлсэн хүмүүнлэг шударга засаглалын бодлого.**

1.1. Ард түмнээ дээдлэх төрт ёсны уламжлал, шударга ёс, тэгш байдлыг тогтоох, хууль ёс дэг журмыг хангах, төрийн албаны сахилгыг эрс чангатгахад чиглэсэн улс төр, эрх зүйн бодлого баримтална. .

1.2. Аливаа хууль, тогтоомж нь төр, байгууллага, албан тушаалтны эрх ашгийг хамгаалдаг өнөөгийн гажиг бодлогыг халж, хуулийг зөвхөн хүний сайн сайхны төлөө, хүнийг хамгаалахын төлөө батлан гаргана.

1.3. Намын болоод амин хувийн зорилгоос ангид байж чадах өндөр мэдлэг, ур чадвар бүхий эх орон, ард түмний язгуур эрх ашгийг эрхэмлэгч, ноён нуруутай, хүнлэг, ёс зүйтэй иргэдээр бүх шатны төрийн албыг бэхжүүлэх бодлого барина.

1.4. Төрийн алба нь ард түмэнд ил тод, алагчлалгүй, шударга, хүртээмжтэй, хүнд сурталгүй үйлчилдэг, цомхон, мэргэшсэн, хариуцлагатай байх эрс шинэтгэлийн бодлого хэрэгжүүлнэ.

1.5. УИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг даргын сонгуульд зөвхөн намууд нэр дэвшүүлдэг одоогийн тогтолцоог өөрчилж иргэний нийгмийн байгууллага, нутаг орны иргэд санал нэгдэн нэр дэвшүүлэх эрхийг хуульчилна.

1.6. Сонгогчдын саналаар УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах, Засаг даргыг огцруулах эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

1.7. Монгол төрийн бодлогын уламжлалыг хадгалсан хүчтэй Ерөнхийлөгчийн засаглалыг дэмжинэ.

1.8. Төрийн өндөр дээд албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэргийг шалгах Мөрдөн шалгах комиссыг УИХ-н дэргэд, хуулийн байгууллагын албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэргийг Мөрдөн шалгах нэгжийг Улсын Ерөнхий Прокурорын дэргэд тус тус байгуулж, хууль, шүүхийн өмнө иргэд эрх тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг хатуу сахиулна.

1.9. Улс орон, ард түмнийг өр зээлийн барьцаанд оруулсан, улсын эдийн засаг, санхүүгийн нөөцийг шавхан хоосолсон, эх орон, ард түмний язгуур эрх ашигт хохирол учруулсан улс төрийн нам, бүлэглэл, улс төрчдөд хуулийн хариуцлага заавал хүлээлгэнэ.

1.10. Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллагын төсөв, мөнгө, хүний нөөц, эд хөрөнгийн зохистой эрх мэдлийн тэнцлийг хангасан эрх зүйн шинэ орчин бүрдүүлнэ.

1.11. УИХ, Засгийн газрын гишүүд болон төр, захиргааны байгууллагын удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх, томилгоо хийхэд эмэгтэйчүүдийн оролцоог эрс нэмэгдүүлнэ.

1.12. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны болон санхүүжилт, зардлын ил тод байдал, үүрэг, хариуцлагын тогтолцоог эрс дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг шинэчлэнэ.

1.13. Авилга, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлэгчийг бүх насаар нь төрийн албанаас зайлуулж, хөрөнгийг нь хурааж, хорих ялын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлнэ.

1.14. Улс төрийн нөлөөнөөс ангид, хүний эрхийг дээдэлсэн, хуулийг ягштал биелүүлдэг шударга шүүх эрх мэдлийг төлөвшүүлэн бүрдүүлэх эрх зүйн шинэтгэлийн бодлого хэрэгжүүлнэ.

1.15. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, ОХУ, БНХАУ-тай стратегийн түншлэлийн харилцаагаа бататган, сайн хөршийн найрсаг харилцааг улам бүр хөгжүүлнэ.

### **Хоёр. Ард түмнээ дээдэлсэн хүмүүнлэг нийгмийн бодлого.**

2.1. Хүүхэд, залуу үедээ монгол хүнээ, эх газар нутаг, унаган байгалиа, уламжлалт түүх, хэл, соёл, ёс заншлаа хайрлан хамгаалах, дээдлэх, сурч мэдэх, бүтээлчээр хөгжүүлэхэд чиглэсэн боловсрол эзэмшүүлж, тэднийг жинхэнэ хүн болж төлөвшүүлэх боловсролын бодлогын шинэчлэл хийнэ.

2.2. Их, дээд сургуулийн хөтөлбөрийг чанаржуулах, нэгтгэх, цөөлөх чиглэлээр хянан магадлаж, УБ хотоос хөдөөд шилжин байрших, инженер технологийн мэргэжлийн элсэгчдийн хувийг нэмэгдүүлэхийг дэмжих бодлого баримтлана.

2.3. Мэргэшсэн ажилтан бэлтгэх, тэднийг үйлдвэрлэлтэй холбоход чиглэсэн боловсролын шинэчлэлийн тогтолцоог бүрдүүлнэ.

2.4. Өнөөгийн төрийн бодлогын гадна буй шинжлэх ухааны салбарын ач холбогдлыг онцгойлон үзэж тууштай дэмжинэ.

2.5. Хүн бүрийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй, төлбөрийн дарамтгүй оношлогоо, эмчилгээ, үйлчилгээнд хамруулах явдлыг эрүүл мэндийн салбарын нэн тэргүүний зорилт болгоно.

2.6. Эмнэлгийн орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг хангаж, зайн оношлогоог нэвтрүүлж, хүн бүрт эрүүл мэндийн үйлчилгээний дэвшилтэт ололтыг хямд хүртээж эх орондоо найдвартай эмчлэгдэх нөхцөлийг бүрдүүлнэ.



*[Handwritten signatures]*



2.7. Хүн ардад ажил, амьдралын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, агаар, хөрс, усны бохирдолтоос болж эрүүл мэндээр хохирогсдын хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх чиглэл барина.

2.8. Ариун тангарагт эмч, эмнэлэгийн ажиллагсад, ардын багш нартаа амьдралд нь хүрэлцэхүйц цалин хөлс олгож, сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх нь нийгмийн бодлогыг тэргүүн зэргийн зорилт гэж үзнэ.

2.9. Хүнээ хамгаалах, хүн амаа өсгөх, хүний хөгжлийг хангах, хүнээ халамжлахад чиглэсэн нийгмийн цогц бодлого явуулна.

2.10. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэд зэрэг зорилтот бүлгийг дэмжих бодлогыг бүтээлчээр үргэлжлүүлж, зорилтот бүлгийн нийгмийн халамжийн тусламж, тэтгэмжийг тогтвортой өсгөх бодлого хэрэгжүүлнэ.

2.11. Нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоог бүрэн шинэчлэх, эрүүл мэндийн даатгалын өгөөжийг эрс нэмэгдүүлэх бодлого баримтлана.

2.12. Хүн амын өргөн хэрэглээний гол нэр төрлийн болон стратегийн бараа, бүтээгдэхүүний үнийг төрөөс зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлнэ.

2.13. Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, цагийн хөлсний хэлбэрийг нэвтрүүлэх, дундаж орлоготой хэсгийг эрс нэмэгдүүлэх, орлого багатай хэсгийг тэтгэж дундаж орлоготны эгнээнд хүргэх бодлого явуулна.

2.14. Аливаа ажил, хөдөлмөрийг гэрээний харилцаанд заавал хамруулж, ажиллагсдыг цалин хөлс, хангамжаа нэмэгдүүлэх, ажлын байраа тогтвортой хадгалах, хөдөлмөрийн мөлжлөгт орохоос хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.15. УБ хотоос хөдөө рүү шилжих хөдөлгөөн өрнүүлж, хөдөлгөөнд нэгдэгсэдийг боломжтой бүх хэлбэрээр урамшуулж, төвлөрлийг сааруулах, орон нутгаа хөгжүүлэх, хамгаалах бодлого баримтална.

2.16. Гэр хорооллыг төвлөрсөн дулаан, цэвэр, бохирын шугамд холбох замаар инженерийн байгууламж бүхий амины орон сууцны хороолол бий болох бодлогыг барина.

2.17. Хүн амын төвлөрөл бүхий хот, суурин газар бүрт усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэл хийх нь ард түмний эрүүл мэндийн баталгааг хангах гол үндэс гэж үзнэ.

### **Гурав. Ард түмнээ дээдэлсэн хүмүүнлэг эдийн засгийн бодлого.**

3.1. Түүхий эдийг дотооддоо боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн гаргах, байгальд ээлтэй, өрсөлдөх чадвартай үйлдвэржилтийг дэмжих бодлого баримтлана.

3.2. Монгол орны бүхий л баялаг, нөөц, боломж, үр өгөөжтэй бүхнийг бизнесийн шударга хуваарилалтаар Ард түмэндээ тэгш хүртээх эдийн засгийн шинэтгэлийн бодлого хэрэгжүүлнэ.



*[Handwritten signature]*

*[Handwritten signature]*

3.3. Дотоодын хязгаарлагдмал хэрэгцээ бүхий зах зээл дээр ижил төрлийн бизнесийг олноороо зэрэгцүүлэн эрхэлж бизнесээ дампууруулдаг, төрийн албан тушаалын эрх мэдэл, төрийн хязгаарлагдмал мэдээллийг олзлон бизнесийн монополь тогтоодог явдлыг таслан зогсоож, эрх тэгш байдлыг хангасан бизнесийн жигд хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.

3.4. Төрийн болон хувийн өмчийн монополь компаниуд иргэдэд хувьцаа эзэмшүүлэх замаар өмч хөрөнгөө ард түмний хяналтад оруулах, өмч хөрөнгийн хэт төвлөрлийг задлах, нийгэмд өмч, орлогын тэгш байдал бүрдүүлэх бодлого баримтлана.

3.5. Үр ашиг муутай барилга, байгууламж, хөшөө суварга барихад зарцуулж буй хөрөнгө оруулалтын болон төрийн захиргааны албаны нүсэр зардлыг эрс багасгах замаар дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн зардлын эзлэх хувийг мэдэгдэхүйц бууруулна.

3.6. Хүн ардын эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалалд түлхүү чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.

3.7. Банкуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, монополь байдлыг халах, хүү багатай зээл олгох, монгол хүний эрх ашигт нийцсэн хүү багатай гадаад эх үүсвэрийг татах, зээлийн хүүгийн дээд хязгаарыг төрөөс хянаж, зохицуулах бодлого хэрэгжүүлнэ.

3.8. Ард түмэнд амьдрах орон гэрээ барих, бизнес эрхлэх зориулалтаар газрыг жинхэнэ утгаар нь тэгш, шударгаар өмчлүүлэх, эзэмшүүлэх, үр ашгийг нь түргэн хүртэх газрын шинэтгэл, дахин хуваарилалтын бодлогыг нэн даруй хэрэгжүүлнэ.

3.9. Төрийн өмчит хуулийн этгээдийг үнэгүйдүүлэн зальт аргаар хувьчилж авсан үйлдлийг илрүүлэх, хувьчлахаар гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, цаашид эрчим хүч, агаарын, төмөр замын болон нийтийн тээвэр, харилцаа холбоо зэрэг стратегийн томоохон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн статусыг хэвээр хадгалах, улмаар архи, спирт, тамхи, казино зэрэгт төрийн өмчийн монополийг бий болгох бодлого баримтлана.

3.10. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог эрс хумиж, бүртгэлийн тогтолцоонд шилжүүлэн төрийн хүнд суртал, авилгыг таслан зогсооно.

3.11. Эрдэс баялгийн тусгай зөвшөөрөл авч, түүнийгээ бусдад худалдаж олсон орлогод татвар ногдуулах, өмнө нь эрх мэдэл, арга заль, луйвраар зөвшөөрөл авч олсон орлогод ногдох татварыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.

3.12. Ард түмний татварын хөрөнгөөр нөөцийг нь тогтоосон ордуудыг шууд төрийн мэдэлд авч, байгальд ээлтэй дэвшилтэт технологийн дагуу олборлолт явуулж үр өгөөжийг нь монгол хүн нэн тэргүүнд хүртэх бодлого баримтлана.

3.13. Нефть бүтээгдэхүүний импорт, бөөний худалдааг төрийн мэдэлд авч, цахилгаан, дулаан, нефть бүтээгдэхүүний үнийг улс даяар нэг төвшинд байлгах бодлого хэрэгжүүлнэ.

3.14. Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, тос боловсруулах үйлдвэрээ ашиглалтанд оруулах, нүүрснээс хий, шингэн түлш гарган энэ төрлийн бүтээгдэхүүний гадаад хамаарлаас ангижрах бодлого баримтлана.



*(Handwritten signature)*

*(Handwritten signature)*



3.15. Гадаадын хөрөнгө оруулалттай бүх аж ахуйн нэгжүүд экспортын орлогоо монголын банкаар дамжуулан гүйцэтгэж санхүүгийн тайлан тэнцлээ монгол хэлээр, монгол төгрөгөөр гаргадаг байх эрх зүйн орчин бүрдүүлж хатуу мөрдүүлнэ.

3.16. Малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, үйлчилгээнд төсвөөс гаргадаг хөрөнгийг эрс нэмэгдүүлж, мал сүргээ бүрэн эрүүлжүүлэх бодлого баримтлана.

3.17. Мал аж ахуйг эрчимжүүлж, малын эрүүлжүүлэлтийг олон улсын стандартад хүргэж, мал аж ахуйн гаралтай бүтээгдхүүний экспортыг нэмэгдүүлэх, дотоодын мах нийлүүлэлтийн тогтолцоог шинэчлэх, мал сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх, бэлчээр хамгаалах бодлого баримтална

3.18. Тариалангийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх, улаанбуудай, хүнсний ногооны импортын хэрэглээг хязгаарлах, тариалалт, хураалтыг улам бүр механикжуулах, агуулахын аж ахуй, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх замаар дотоодын хэрэглэгчдийн болон үрийн нөөцийн хэрэгцээг бүрэн хангаж улмаар экспортын боломжийг бүрдүүлэх бодлого баримтлана.

#### **Дөрөв. Ард түмнээ дээдэлсэн хүмүүнлэг байгаль экологи, аюулгүй орчны бодлого.**

4.1. Цэвэр онгон байгалиа хойч үедээ өвлүүлэн үлдээх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, ард олон газар нутгаа зохистойгоор эзэмшиж, үр шимийг нь шударгаар хүртэх бодлого баримтлана.


4.2. Ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчин, хууль бус мод бэлтгэлээс хамгаалах, нөхөн сэргээх, мод орлох технологийг нэвтрүүлэх чиглэлээр бодлогын шинэчлэл хийнэ.

4.3. Ард түмний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг идэвхит болон химийн хорт бодисын хэрэглээг багасгах, хязгаарлах, хор хөнөөл ихтэй уурхай, үйлдвэрийг эдийн засгийн үр ашгийг харахгүйгээр шууд хаах бодлого баримтлана.

4.4. Ард түмнийхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор уул уурхай, бусад байгалийн баялагийн нөхөн сэргээлт хийгээгүй иргэн, аж ахуйн нэгжид ногдуулах хариуцлагыг эрс чангатгах, байгаль орчинд хохирол учруулсан талаархи бодитой мэдээлэлийг урамшуулах, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоох эрх зүйн орчин бүрдүүлнэ.

4.5. Ашигт малтмалыг хайх, олборлох, газар, бэлчээрийг эзэмших, өмчлөх эрх гагцхүү ард түмний бүрэн мэдэлд байж, газрын хэвлийн баялгийг ашиглахад заавал Монгол улсын иргэн оролцсон тохиолдолд ашиглуулдаг байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

4.6. Цөлжилтийг зогсоох, бэлчээрийн хэт талхагдлыг бууруулах, устах аюулд орж байгаа амьтан, ургамлаа хамгаалах ажлыг ард иргэдийнхээ санаачлага, дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэгт тулгуурлан монгол төрийн бодлогын тэргүүн эгнээнд тавина.



*(Handwritten signature)*

*(Handwritten signature)*

4.7. Усны нөөцийн ашиглалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэл болон ахуйн хэрэгцээнд гадаргын усны нөөц, илүүдэл ус (шар усны үер)-ыг ашиглах, хот, суурин газрын болон уул уурхайн үйлдвэрлэлийн бохир усыг цэвэршүүлэх, эргүүлэн ашиглах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн үйлдвэрлэлд газрын гүний ус ашиглахыг зогсоох бодлого баримтлана.

4.8. Генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлэх хүчин чадварыг бүрдүүлж, гаднаас оруулах, хэрэглэхийг хуулиар хориглоно.

4.9. Хүнсний аюулгүй байдлын стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, мөнхүү шаардлагад нийцсэн тээвэр, агуулахын сүлжээ, ложистик байгуулах бодлого хэрэгжүүлнэ.



МОНГОЛЫН ГҮМӨН МАНДАВ БАДРАГ !!!





АРД ТҮМНЭЭ ХАЙРЛАЯ НАМД

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.04.21 № 1231  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох “Ард түмнээ хайрлая нам”-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

“Ард түмнээ хайрлая нам”-ын Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3. дахь хэсэг, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ард түмнээ хайрлая нам”-ын мөрийн хөтөлбөр /.....<sup>6</sup>..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2020\0421NAG22.Docx

001052139